



Монгол улсын хэргийн
№ 01 дүгээр сарын 17
№3 /672/

УНШЛААГ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

114

**Монгол Улсын Үндсэн хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах
журмын тухай**

Монгол Улсын
хууль

139

**Монгол Улсын Их Хурлын
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
орлуулах тухай**

Монгол Улсын
эргийн газрын
тогтоол

148

**“Эрдэнэс-Тавантолгой” ХК
байгуулах тухай**

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- | | | |
|-----|---|-----|
| 13. | Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай | 114 |
| 14. | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 126 |
| 15. | Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 139 |
| 16. | Монгол Улсын гэмдэгтийн хураамжийн хууль хүчингүй болсонд тооцох тухай | 145 |
| 17. | Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах тухай | 145 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|-----|--|-----|
| 18. | Журамд өөрчлөлт оруулах тухай Дугаар 74 | 146 |
| 19. | Доминиканы Бүгд Найрамдах Улстай дипломат харилцаа тогтоох тухай Дугаар 76 | 146 |
| 20. | Шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээг тогтоох тухай Дугаар 77 | 147 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | |
|-----|---|-----|
| 21. | Зарим хүнийг Ерөнхий шүүгчийн албан тушаалд томшилох тухай Дугаар 270 | 147 |
| 22. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 271 | 148 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | |
|-----|--|-----|
| 23. | “Эрдэнэ-Тавантолгой” ХК байгуулах тухай Дугаар 272 | 148 |
| 24. | Үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 275 | 150 |

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- | | | |
|-----|---|-----|
| 25. | Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуудлийг шүүхийн практикт дагаж мөрдөх журмын тухай Дугаар 29 | 163 |
|-----|---|-----|



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт, зохицуулах харилцаа

1.1.Монгол Улсын Үндсэн хуулийг¹ дээдлэн сахиж, хүндэтгэн биелүүлэх, түүний тогтвортой байдлыг хангах нь Монгол Улсын тусгаар тогтносон, бүрэн эрхт байдлаар оршин тогтнохуйн эрх зүйн үндэс, Монгол Улсын Их Хурлын онцгой чухал үүрэг мөн бөгөөд энэ хүрээнд уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран найм, Жаран есдүгээр зүйлд заасан үндэслэлийн дагуу хянан шийдвэрлэх үйл ажиллагааны зарчим, журмыг энэ хуулиар тодорхойлж зохицуулна.

1.2.Энэ хуулиас гадуур Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг завдах, хуйвалдан оруулах аливаа үйлдлийг Монгол Улсын Үндсэн хуульд байгуулалд халдсан хэрэг гэж үзнэ.

1.3.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай энэхүү хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийг бүхэлд нь хянан үзэж шинээр батлахтай холбогдсон харилцааг зохицуулахгүй.

2 дугаар зүйл.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн агуулга, хязгаар

2.1.Монгол Улсын Үндсэн хууль /цаашид "Үндсэн хууль" гэх/-ийн бүлэг, зүйл, хэсэг, заалтад байхгүй шинэ томъёоллоор зохих бүлэгт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтыг Үндсэн хуулийн нэмэлт гэх бөгөөд тэр нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцсэн байна.

2.2.Үндсэн хуулийн зохих бүлэгт шинээр зүйл нэмсэнээр түүний дараахь зүйлийн дугаарыг өөрчлөхгүй бөгөөд нэмсэн зүйл, хэсэг, заалтын

¹ Монгол Улсын Үндсэн хууль –Төрийн мэдээлэл эхлэлтэйгэн 1092-амы 1 дугаарт нийтлэгдсэн.



дугаарыг тэмдэглэхдээ баруун дээд өнцөгт нь араб тоогоор дугаарлана.
(Хорин тав'дүгээр зүйл г.м).

2.3. Үндсэн хуулийн зохих бүлэг, зүйл, хэсэгт байгаа заалтын нэр томъёог тодруулах, найруулгыг сайжруулахаар оруулж байгаа заалтыг Үндсэн хуулийн өөрчлөлт гэх бөгөөд тэрхүү өөрчлөлт нь энэ хуулийн 2.1-д заасан шаардлагыг хангасан байна.

2.4. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалыг өөрчлөх буюу нийт зүйлийн 35, түүнээс дээш хувийг өөрчлөх, эсхүл түүнтэй тэнцэх тоо хэмжээний нэмэлт оруулахаар байвал энэ нь Үндсэн хуулийг бүхэлд нь өөрчлөх буюу хянан үзэхэд хамаарна.

3 дугаар зүйл. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болох нөхцөл

3.1. Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон тохиолдолд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно.

3.2. Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын Их Хурал /цаашид "Улсын Их Хурал" гэх / ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно.

3.3. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийг нэгэнт оруулсан бол энэ тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш найман жилийн дотор уг асуудлаар нэмэлт, өөрчлөлт дахин оруулахыг хориглоно.

3.4. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэж эхэлсэн бол түүнийг Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 18 дахь заалт болон мөн зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар онц болон дайны байдал тогтоосныг цуцалтал түдгэлзүүлэн зогсооно.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "хууль санаачлагч" гэж Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч /цаашид "Ерөнхийлөгч" гэх/, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрыг;



4.1.2. "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл" гэж хууль санаачлагчаас Үндсэн хуулийн ач холбогдол, өндөр шаардлагыг хангахуйц мэргэжлийн түвшинд боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийн эх бичвэрийг.

5 дугаар зүйл. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны үндсэн зарчим

5.1. Улсын Их Хурал, хууль санаачлагч нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны бүх үе шатанд дараахь үндсэн зарчмыг баримтална:

5.1.1. Үндсэн хуулийг дээдлэн сахих, түүний тогтвортой байдлыг хамгаалах;

5.1.2. ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах;

5.1.3. бодитой, ил тод байх.

5.2. Улсын Их Хурал, хууль санаачлагч нь энэ хуулийн 5.1.1-д заасан зарчмыг дор дурдсан үндсэн арга замаар хангана:

5.2.1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл /цаашид "төсөл" гэх/ нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд харшлахгүй байх;

5.2.2. Үндсэн хуулийн Нэг, Хоёр, Гурав, Дөрөвдүгээр зүйл, Тавдугаар зүйлийн 1-4 дэх хэсэг, Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аравдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөв, Арван тав, Арван ес, Хорьдугаар зүйл, Хорин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин нэг, Дөчин долдугаар зүйл, Дөчин есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Жаран найм, Жаран есдүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно;

5.2.3. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны журам нь Үндсэн хуулийн Жаран найм, Жаран есдүгээр зүйлд бүрнээ нийцсэн байх;

5.2.4. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна.

5.3. Улсын Их Хурал, хууль санаачлагч нь энэ хуулийн 5.1.2-т заасан зарчмыг дор дурдсан үндсэн арга замаар хангана:

5.3.1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төсөл санаачлах үеэс эхлэн батлах хургал бүхий тусгай ажиллагаанд иргэд, улс төрийн нам, олон нийтийн бусад байгууллагын оролцоог хангах;

5.3.2.иргэдэд төслийн талаар саналаа чөлөөтэй илэрхийлэх бололцоог олгох.

5.4.Улсын Их Хурал, хууль санаачлагч нь энэ хуулийн 5.1.3-т заасан зарчмыг дор дурдсан үндсэн арга замаар хангана:

5.4.1.Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга, үйл ажиллагаа нь дур зоргын шинжтэй байж болохгүй;

5.4.2.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь улс төрийн аль нэгэн нам, бүлэг, давхаргын ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалсан байж болохгүй;

5.4.3.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хүний үндсэн эрх, эрх чөлөөг дордуулсан, төрийн эрх мэдлийг хуваарилсан зарчмыг үгүйсгэсэн байж болохгүй;

5.4.4.төслийн бүрэн эх болон түүнийг өргөн мэдүүлэх, хэлэлцэх, шийдвэр гаргах үйл ажиллагаа, эцсийн үр дүнг хэлэлц мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж байх;

5.4.5.төслийн талаархи иргэдийн болон тэдгээрийн хамт олон, байгууллагын саналыг Улсын Их Хурлын олон нийттэй харилцах бүх сувгаар хүлээн авч, төсөлд хэрхэн тусгасан тухай мэдээлж байх;

5.4.6.төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо шууд болон өөрийн бие төлөөлөгчөөр дамжуулан уг үйл ажиллагааны үр дүнг мэдээлж, иргэдийн санаа бодлыг судалж, харгалзан үзэх;

5.4.7.төслийн хэлэлцүүлгийн үе шат хоорондын хугацааг иргэд, тэдгээрийн хамт олон, байгууллагад санал бодлоо илэрхийлэх боломж олгохуйцаар тогтоох.

6 дугаар зүйл. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах

6.1.Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

6.2.Улсын Их Хурал хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн төсөлгүйгээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж болохгүй.

7 дугаар зүйл.Ерөнхийлөгч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах

7.1.Ерөнхийлөгч нь төрийн тэргүүний хувьд энэ хуулийн 5.2.2-т



зааснаас болон дор дурдсанаас бусад асуудлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачилж болно:

7.1.1. Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгосон бүрэн эрхийг өргөтгөх, хязгаарлах, эрх хэмжээг нэмэгдүүлэх;

7.1.2. Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн болон үлдсэн бүрэн эрхийн хугацааг сунгах, бусад байдлаар өөрчлөх;

7.1.3. Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлагыг сулруулах, өөрчлөх.

7.2. Үндсэн хуулийн Гучин долдугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь хэрэгжүүлж байгаа үедээ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачилж болохгүй.

8 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах

8.1. Улсын Их Хурлын гишүүн энэ хуулийн 5.2.2-т зааснаас болон дор дурдсанаас бусад асуудлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачилж болно:

8.1.1. Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн болон бүрэн эрхийн хугацааг сунгах;

8.1.2. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг өргөтгөх, үүрэг, хариуцлагыг сулруулах;

8.1.3. Гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн тодорхой бүрэн эрхийг олж авах.

8.2. Улсын Их Хурлын гишүүн энэ хуулийн 8.1-д заасан төслийг Улсын Их Хурлын бусад гишүүнтэй хамтран санаачилж болно.

9 дүгээр зүйл. Засгийн газар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах

9.1. Засгийн газар нь энэ хуулийн 5.2.2-т зааснаас болон дор дурдсанаас бусад асуудлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачилж болно:

9.1.1. Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хязгаарлах, өөрчлөх;

9.1.2. Шүүх эрх мэдлийг хязгаарлах, өөрчлөх;

9.1.3. Засгийн газрын гишүүний эрх хэмжээг нэмэгдүүлэх.

9.2. Энэ хуулийн 9.1-д заасан төслийг Засгийн газрын хуралдаанаар



хэлэлцэж дэмжсэн байна.

10 дугаар зүйл. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тавих шаардлага

10.1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл нь дор дурдсан нийтлэг шаардлагыг хангасан байна:

10.1.1.Үндсэн хуулийн зохих зүйл болон энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчимд бүрэн нийцэж байгааг буюу харшлаагүйг нотолсон тайлбар хавсаргасан байх;

10.1.2.Монгол Улсын олон улсын гэрээнд харшлаагүй тухай болон хэрэв Монгол Улсын олон улсын гэрээтэй зөрчилдөхөөр байвал түүнээс гарах арга замыг тус тус тодорхойлсон байх;

10.1.3.төслийн талаар Ерөнхийлөгч, Засгийн газрын санал авсан байх;

10.1.4.үндэсний аюулгүй байдалтай холбогдсон асуудлаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, санал авсан байх;

10.1.5.шүүх эрх мэдэлтэй холбогдсон асуудлаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн, хүний эрхийн асуудлаар Хүний эрхийн Үндэсний Комиссын санал авсан байх;

10.1.6.мөнгө, зээлийн асуудлаар Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцсөн байх.

10.2.Энэ хуулийн 10.1.3-10.1.6-д заасан байгууллага, албан тушаалтан төслийн талаар саналаа 30 хоногт багтаан хууль санаачлагчид хүргүүлэх ба шаардлагатай бол хууль санаачлагчтай тохиролцон энэ хугацааг хойшлуулж болно.

10.3.Энэ хуулийн 10.1.3-10.1.6-д заасан байгууллага, албан тушаалтан мөн хуулийн 10.2-т заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦЭХ

11 дүгээр зүйл. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэх

11.1.Хууль санаачлагч энэ хуульд заасан зарчим, журмын дагуу боловруулсан төслөө Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл



боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд² заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

11.2. Улсын Их Хурал төслийг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эхэлнэ.

11.3. Төслийг чуулганаар хэлэлцэхэд дараахь зарчмыг баримтална:

11.3.1. Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт /76/ гишүүний дөрөвний гурав /57/ -аас доошгүйн ирцтэй бол түүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг авч хэлэлцэхэд хүчин төгөлдөр гэж үзнэ;

11.3.2. Улсын Их Хурлын гишүүн хуралдаанд биеэр оролцож, саналаа өгнө. Бусдыг төлөөлж санал өгөхийг хориглоно;

11.3.3. Төслийг батлахдаа гурван хэлэлцүүлгээр шийдвэрлэнэ. Нэг болон хоёр дахь хэлэлцүүлгээр төслийг эцэслэн батлахыг хориглоно;

11.3.4. Чуулганаар урьдчилан тогтсон зөвхөн нэг төсөл хэлэлцэнэ. Өөр өөр үзэл баримтлалтай хоёр буюу хэд хэдэн төслийг саналын түвшинд харгалзан үзэж болох ба харин бие даасан байдлаар зэрэгцүүлэн хэлэлцэхийг хориглоно;

11.3.5. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд санал хураалтыг асуудлын шинж байдал, нөхцөл байдлыг харгалзан илээр, эсхүл нууцаар хурааж болох бөгөөд аль хэлбэрээр санал хураахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ;

11.3.6. Хэлэлцүүлгийг тасралтгүй явуулна. Төслийг чуулган нэгэнт хэлэлцэж эхэлсэн бол эцсийн шийдвэр гартал Улсын Их Хурал өөр асуудал хэлэлцэхгүй.

11.4. Хэлэлцүүлэг хоорондын хугацаа хэлэлцэж байгаа асуудлын шинж байдал, цар хэмжээнээс хамааран долоогоос доошгүй ажлын өдөр байх бөгөөд дээд хязгаарыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар тогтоож болно. Энэ хугацаанд Байнгын хороо, гишүүд олон нийтийн санал бодлыг сонсох, төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг хийж, санал, дүгнэлтээ гаргана. Энэ нь тасралтгүй ажиллагаанд хамаарна.

11.5. Энэ хуулийн 11.3.6 дахь заалт нь хэлэлцүүлгийн үе шат хооронд зохион байгуулалтын болон нэг удаагийн /хэм хэмжээний бус/

² Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 46 дугаарт нийтлэгдсэн.



шинжтэй хойшгуулшгүй асуудлыг шийдвэрлэхэд хамаарахгүй.

12 дугаар зүйл.Нэг дэх хэлэлцүүлэг явуулах журам

12.1.Улсын Их Хурлын чуулган төслийг цаашид хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэхдээ дор дурдсан дэс дараалал, журмыг баримтална:

12.1.1.хууль санаачлагчийн илтгэлийг сонсох;

12.1.2.илтгэлтэй холбогдуулж асуулт, хариулт явуулах;

12.1.3.Байнгын хорооны санал, дүгнэлт сонсох;

12.1.4.нам, эвслийн бүлэг төслийн үзэл баримтлалын талаар намынхаа бодлого, байр суурийг илэрхийлж болно;

12.1.5.өөрөө хүсэлт тавьсан бол Ерөнхийлөгч үг хэлэх;

12.1.6.Үндсэн хуулийн цэц санал ирүүлсэн бол түүнийг сонсох;

12.1.7.Засгийн газрын саналыг сонсох;

12.1.8.Улсын Их Хурлын гишүүн үг хэлж, санал гаргах;

12.1.9.Улсын Их Хурлын дарга иргэд, олон нийтийн зүгээс ирүүлсэн шүүмж, мэдээллийг чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгож болно;

12.1.10.төслийг цаашид хэлэлцэх эсэх талаар "эвшөөрнө", "татгалзана" гэсэн томъёоллоор санал хураах.

12.2.Төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзвэл Улсын Их Хурал төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх Ажлын хэсгийг хууль санаачлагчийг оролцуулан байгуулж болно.

13 дугаар зүйл.Хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх журам

13.1.Хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг Төрийн байгуулалтын байнгын хороо нэгтгэн зохицуулна.

13.2.Бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцэж Төрийн байгуулалтын байнгын хороонд өгнө.

13.3.Нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргаж болно. Байнгын хороо болон түүний гишүүн, мөн нам, эвслийн бүлэг нь төсөлд тусгагдаагүй шинэ хэсэг, заалтын томъёоллыг санал, дүгнэлтдээ оруулж болохгүй.

13.4.Төрийн байгуулалтын байнгын хороо санал, дүгнэлтдээ дараахь зүйлийг тусгана:



13.4.1.төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаархи мэдээлэл;

13.4.2.төсөлд Байнгын хороод, нам, эвслийн бүлгээс өгсөн санал, дүгнэлт, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй санал;

13.4.3.энэ хуулийн 13.4.2-т заасан зарчмын зөрүүтэй саналаас төсөлд тусгах шаардлагагүй гэж үзсэн бол түүний үндэслэл, шалтгаан;

13.4.4.төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах тухай Байнгын хорооны санал хураалтын дүн.

14 дүгээр зүйл.Хоёр дахь хэлэлцүүлэг явуулах журам

14.1.Төрийн байгуулалтын байнгын хорооноос энэ хуулийн 13 дугаар зүйлд зааснаар төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай санал, дүгнэлтийг эхлээд сонгоно.

14.2.Энэ хуулийн 14.1-д заасан санал, дүгнэлтийг сонгосны дараа Улсын Их Хурлын гишүүд зөвхөн Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, тайлбар авч болно.

14.3.Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүдээс төсөлд оруулахаар гаргасан зарчмын зөрүүтэй саналыг тусад нь хэлэлцүүлэхгүй, харин хоёр дахь хэлэлцүүлэгт оруулсан төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр нь дэс дараалан санал хураалт явуулахдаа хамтатган хэлэлцэнэ.

14.4.Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр санал хураана.

14.5.Энэ хуулийн 14.4-т заасны дагуу санал хураалт явуулж дууссаны дараа төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоосон Улсын Их Хурлын тогтоолыг баталж, төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж, энэ тухай нийтэд зарлан мэдээлнэ.

15 дугаар зүйл.Гурав дахь хэлэлцүүлэг явуулах журам

15.1.Төслийн гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг эхлээд сонгоно.

15.2.Хоёр дахь хэлэлцүүлгийн санал хураалтаар төслийн зүйл, хэсэг, заалтад өөрчлөлт орж, түүнд найруулга хийсэн бол энэ тухай



Төрийн байгуулалтын байнгын хорооны тайлбарыг сонссоны дараа түүний найруулгын томъёоллыг уншж, томъёолол тус бүрээр санал хураана.

15.3.Энэ хуулийн 15.2-т заасан санал хураалтын дүнтэй санал нийлээгүй Улсын Их Хурлын гишүүн нэг удаа үндэслэл, шалтгаанаа тайлбарлаж санал хураалгах эрхтэй. Хэрэв уг санал дэмжигдвэл тухайн зүйл, хэсэг, заалтын найруулгыг сонсож, дахин санал хураана. Улсын Их Хурлын гишүүн, цөөнх хоёр дахь хэлэлцүүлгээр батлагдсан саналаасаа зөрүүтэй болон өөр зүйл, хэсэг, заалт нэмэх санал гаргаж болохгүй.

15.4.Энэ хуулийн 15.2, 15.3-т заасан санал хураалт дууссаны дараа төслийг бүхэлд нь уншиж сонсон Улсын Их Хурлын дарга зүйл, хэсэг, заалт нэг бүрээр санал хураалт явуулна.

15.5.Энэ хуулийн 15.4-д заасны дагуу санал хураахад Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авсан зүйл, хэсэг, заалтыг батлагдсанд тооцно.

15.6.Энэ хуулийн 15.5-д заасан хувь хэмжээний санал аваагүй зүйл, хэсэг, заалтыг төслөөс хассанд тооцож, энэ тухай Улсын Их Хурлын тогтоол гаргана.

15.7.Улсын Их Хурлын дарга төслийг уншиж дууссаны дараа хуулийг бүхэлд нь батлах саналыг хураана.

15.8.Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурав, түүнээс дээш хувь нь "батлах" санал өгсөн бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль батлагдсанд тооцож, нийтэд зарлан мэдээлнэ.

**16 дугаар зүйл.Ерөнхийлөгч Үндсэн хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах хуулийн уг эхийг нотлох,
хадгалах, албан ёсны эхийг нийтлэх**

16.1.Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг баталснаас хойш ажлын хоёр өдрийн дотор Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчид биеллэн хүргэж танилцуулна.

16.2.Ерөнхийлөгч Улсын Их Хурлаас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн уг эхийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын долоо өдрийн дотор хянан үзэж хэрэв уг хууль бүхэлдээ буюу түүний аль нэг зүйл, хэсэг, заалт, нэр томъёоны агуулга нь Үндсэн хуульд харшилсан гэж үзвэл Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар хориг тавьж болно.



16.3.Ерөнхийлөгч "Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ... оны ... дугаар сарын ...-ны өдрийн хуулийн уг эх мөн болой. Монгол Улсын Ерөнхийлөгч ..." гэсэн гарын үсэг зурж, төрийн тамга дарж баталгаажуулан Үндсэн хуулийн уг эхийн хамтад хадгална.

16.4.Ерөнхийлөгчийн нотлон баталгаажуулсан уг эхийг Үндсэн хуульд байршуулж, "Төрийн мэдээлэл" эмхтгэлд нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эхэд тооцно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГААР ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ

17 дугаар зүйл. Ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

17.1.Улсын Их Хурал төслийг энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар хэлэлцээд тухайн нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар тогтвол Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалт, Жаран наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоол гаргана.

17.2.Ард нийтийн санал асуулгад оруулах төслийг Үндсэн хууль, энэ хуульд заасан бүхий л зарчим, шаардлага, журмыг баримтлан боловсруулж чуулганы нэг, хоёр дахь хэлэлцүүлгээр хянан хэлэлцэнэ.

17.3.Хоёр дахь хэлэлцүүлгээр зүйл, хэсэг, заалт бүрээр санал хурааж шийдвэрлэсэн төслийг ард нийтийн санал асуулгад оруулах эх болгон баталж уг эхээр ард нийтийн санал асуулга явуулах тухай Улсын Их Хурлын тогтоол гаргана.

17.4.Ард нийтийн санал асуулга явуулах тухай Улсын Их Хурлын тогтоолд ард нийтийн санал асуулга явуулах болсон шалтгаан, зорилго, санал асуулга эхлэх, дуусах он, сар, өдөр, уг ажлыг зохион байгуулах журмыг тодорхойлно.

17.5.Ард нийтийн санал асуулгад оруулж байгаа төслийг санал асуулга явуулах өдрийг зарлан тунхагласнаас хойш ажлын гурван өдрийн дотор албан ёсоор нийтэлнэ.

17.6.Төслийг зөвшөөрөх, эсхүл татгалзах тухай ард нийтийн санал



асуулгыг Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд заасны дагуу зохион байгуулж явуулна.

17.7. Ард нийтийн санал асуулгад санал хураах өдөр 18 насанд хүрсэн сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэд нийтээрээ, тэгш, шууд, чөлөөтэй, саналаа нууцаар гаргах журмаар оролцох бөгөөд уг ажлыг Улсын Их Хурлын сонгуультай зэрэгцүүлэн явуулж болно. Хэрэв өөр цаг үед явуулж байгаа бол Улсын Их Хурлын өмнөх сонгуулийн үед гаргасан сонгогчдын нэрийн жагсаалтын үндсэн дээр түүнийг шинэчлэн баталгаажуулж, зохион байгуулна.

17.8. Ард нийтийн санал асуулгад сонгогчдын нэрийн жагсаалтад хууль ёсоор бичигдсэн нийт иргэдийн олонхи нь оролцож, тэдгээрийн олонхи нь уг хуулийг "зөвшөөрнө" гэсэн санал өгсөн бол Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль батлагдсанд тооцно.

17.9. Ард нийтийн санал асуулгаар батлагдсан хуулийг албажуулах, нийтлэх, хүчин төгөлдөр болсонд тооцох асуудлыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо зохион байгуулна.

17.10. Ард нийтийн санал асуулгаар батлагдсан хуульд Улсын Их Хурал ямар нэгэн засвар, өөрчлөлт оруулах, Үндсэн хуулийн цэц хянан хэлэлцэхийг хориглоно.

17.11. Ард нийтийн санал асуулгад иргэдийн олонхи нь оролцоогүй бол санал асуулгыг хүчингүйд, санал хураалтад оролцогчдын олонхи нь "татгалзана" гэсэн санал өгсөн бол уг хуулийг батлагдаагүйд тооцно. Санал асуулгыг хүчингүйд тооцсон, хуулийг батлахаас ийнхүү татгалзсан бол санал асуулгын дүн гарсан өдрөөс хойш Улсын Их Хурал найман жилийн дотор дахин авч хэлэлцэхгүй.

17.12. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар нутаг дэвсгэрийн хороо, хэсгийн хэмжээнд дахин санал авах, санал асуулгыг улсын хэмжээнд дахин явуулах ажлыг Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн⁵ 25 дугаар зүйл, 26 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэгт заасныг баримтлан хэрэгжүүлнэ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

⁵ Ард нийтийн санал асуулгын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.11-4.12 дахь хэсэг:

“4.11.Төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаанд Улсын Их Хурлын олонхи гишүүн оролцох, хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан нам, эвслийн бүлэгт саналаа зөвшилцөх боломж олгох зорилгоор хуралдаан даргалагч нэгдсэн хуралдааны эхлэх цагийг энэ хуулийн 4.1-д зааснаас өөрөөр тогтоож болно.

4.12.Хуралдааныг 18.00 цагаас хойш үргэлжүүлэн хуралдуулах асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.”

2/6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг:

“6.6.Энэ хуулийн 5.2-т заасан хаалттай хуралдаанд асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд оролцож болох бөгөөд хуралдааны явцыг энэ хуулийн 54.1-д заасны дагуу тэмдэглэнэ.”

3/7 дүгээр зүйл:

“7 дүгээр зүйл.Нээлттэй сонголт

7.1.Байнгын, дэд хороо тодорхой асуудлын талаар эрдэмтэд, шинжээчид, сонирхлын бүлэг, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын санал сонсох, мэдээлэл авах зорилгоор дараахь журмаар нээлттэй сонголт /цаашид “сонголт” гэх/ зохион байгуулж болно:

7.1.1.Байнгын, дэд хорооны дарга сонголын сэдэв, ягш, цэгийг нэг сарын өмнө тсвлох бөгөөд энэ тухай мэдээллийн хэрэгсэл болон цахим сүлжээгээр нийтэд мэдээлэх;



7¹.1.2.тодорхой асуудлын талаар санал хэлэх, мэдээлэл хийх иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, холбогдох бусад хүмүүс /цаашид "сонсголд оролцогч" гэх/ уг сонсгол болохоос ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө холбогдох Байнгын, дэд хороонд мэдэгдэж бүртгүүлэх, илтгэл, санал, мэдээллээ өгөх;

7¹.1.3.сонсголд оролцогч санал хэлэх, мэдээлэл хийх дарааллыг сонсгол даргалагч тогтоох;

7¹.1.4.сонсголд оролцогч нь 10 минутаас илүүгүй хугацаанд санал, мэдээллээ танилцуулах;

7¹.1.5.гишүүн сонсгол даргалагчийн тогтоосон хугацаанд санал, мэдээлэлтэй нь холбогдуулж асуулт асуух;

7¹.1.6.сонсголд оролцогч нь гишүүдээс асуулт асуухгүй бөгөөд сонсгол даргалагчийн зөвшөөрснөөр 2 минутаас илүүгүй хугацаанд гишүүдийн асуултад хариулах, тайлбар хийх;

7¹.1.7.Байнгын, дэд хороо сонсголын явцад гарсан саналыг нэгтгэн тухайн асуудлыг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт өгөх.

7¹.2.Энэ хуулийн 7¹.1-д заасны дагуу тодорхой асуудлын талаар Байнгын, дэд хорооны сонсголыг нэгдсэн болон Байнгын, дэд хорооны хуралдаантай давхардуулахгүйгээр зохион байгуулах бөгөөд сонсголыг чуулганы чөлөөт цагт зохион байгуулж болно.

7¹.3.Сонсголын үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудлыг Байнгын, дэд хороо, Тамгын газар хариуцан зохион байгуулна."

4/8 дугаар зүйлийн 8.7-8.10 дахь хэсэг:

"8.7.Нэгдсэн хуралдаанаар асуудал хэлэлцэхэд энэ хуулийн 18.1-д заасан холбогдох Байнгын хорооны дарга, эсхүл түүнийг орлож байгаа гишүүн хуралдаанд заавал оролцоно.

8.8.Гишүүн тодорхой асуудлын хэлэлцүүлгийн явцад гаргасан зарчмын зөрүүтэй саналаа нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийн явцад татан авч болно."

5/9^а дүгээр зүйл:

"9^а дүгээр зүйл.Санал хураалт явуулах ерөнхий журам

9^а.1.Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг ил болон нууц



санал хураалтаар шийдвэрлэнэ.

9^{1.2}.Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим тоолуураар, нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тоолуураар явуулна.

9^{1.3}.Санал хураах хуудас ашиглан нууц санал хураалт явуулах бол Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн тооллогын комисс байгуулан санал хураалт явуулж, дүнг танилцуулна.

9^{1.4}.Цахим тоолуураар нууц санал хураалт явуулах бол зөвхөн санал хураалтын дүн гарах бөгөөд санал өгсөн гишүүдийн нэрс цахим тоолуурын системд хадгалагдахгүй.

9^{1.5}.Санал хураалт явуулах үед гишүүн санал өгөх эрхээ зөвхөн өөрөө эдлэх бөгөөд энэхүү эрхээ бусдад шилжүүлэх, бусад гишүүний өмнөөс санал өгөхийг хориглоно.

9^{1.6}.Гишүүн шийдвэр гаргах асуудлаар өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хувьд ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл санал хураалтад оролцохоос сайн дураар татгалзах бөгөөд энэ тухайгаа хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэнэ.

9^{1.7}.Энэ хуулийн 9^{1.6}-д заасны дагуу гишүүн санал хураалтад оролцохоос татгалзсан бол түүнийг тухайн санал хураалтын ирцэд оруулахгүй.”

6/10¹ дүгээр зүйл:

“10¹ дүгээр зүйл.Хуралдааны дэг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

10^{1.1}.Гишүүн хуралдааны дэг зөрчсөн бол хуралдаан даргалагч дараахь хариуцлага хүлээлгэнэ:

10^{1.1.1}.сануулах;

10^{1.1.2}.сануулга авсан гишүүн дахин зөрчил гаргавал түүний тухайн өдрийн хуралдаанд, эсхүл тухайн хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асуух, үг хэлэх эрхийг нь хасах;

10^{1.1.3}.хуралдааны дэгийг, удаа, дараа зөрчсөн, хуралдааныг хэвийн явуулахад саад учруулж байгаа гишүүний хуралдааны



санал хураалтаас бусад үйл ажиллагаанд оролцох эрхийг нь 3 цаг хүртэл хугацаагаар хасах. Хугацааг хуралдаан даргалагч тогтоож хуралдаанд мэдэгдэнэ;

10¹.1.4.хуралдааны явцад ёс зүйн зөрчил гаргасан гэж үзвэл тухайн гишүүний талаар Ёс зүйн дэд хороонд санал тавих.”

7/16 дугаар зүйлийн 16.11-16.15 дахь хэсэг:

“16.11.Төслийг хэлэлцэхдээ тухайн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг баримтлах бөгөөд тухайн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд орсон боловч хэлэлцэж амжаагүй төслийг дараагийн ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулж хэлэлцэн батална.

16.12.Хуралдаанаар нэг асуудлыг хэлэлцэж эхэлсэн боловч түүний хэлэлцүүлгийг хойшлуулж дараагийн асуудлыг хэлэлцэх эсэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

16.13.Энэ хуулийн 16.5-д заасан ажлын хэсгийг байгуулахдаа ахлагчийг томилох бөгөөд ахлагчид нэг хүн дэвшвэл шууд, нэгээс илүү хүн нэр дэвшвэл илээр санал хураалт явуулж сонгоно.

16.14.Ажлын хэсэг 5-7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийн ахлагч олонхи, цөөнхийн харьцааг харгалзан бүрэлдэхүүнийг өөрөө сонгох бөгөөд ингэхдээ ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ахлагчид нэр дэвшсэн бусад гишүүнийг оруулсан байна.

16.15.Байнгын хороо хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө Ерөнхийлөгч, Засгийн газар уг төсөлтэй холбогдуулан санал ирүүлсэн бол тухайн Байнгын хороо төслийн анхны хэлэлцүүлэг хийх үед уг саналыг хуралдаан даргалагч танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл гишүүд асуулт асууж, тайлбар авч болно.”

8/22 дугаар зүйлийн 22.3.5 дахь заалт:

“22.3.5.хуралдаан даргалагч санал хураалт явуулах цагийг урьдчилан товлож зарлах бөгөөд санал хураалт явуулахаас 5 минутын өмнө тусгайлан дохио өгч гишүүдэд мэдэгдэнэ.”

9/25 дугаар зүйлийн 25.16 дахь хэсэг:

“25.16.Шаардлагатай гэж үзвэл төсвийн тухай хууль батлагдсантай



холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолыг энэ хуульд заасан журмын дагуу хэлэлцэн баталж болно.”

10/30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг:

“30.4.Засгийн газар гадаад улстай дипломат харилцаа тогтоох, эсхүл цуцлах асуудлаар тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн бол уг асуудлыг энэ хуулийн 30.1-д заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.”

11/36¹ - 36⁴ дүгээр зүйл:

“36¹ дүгээр зүйл.Зохион байгуулалтын шинжтэй бусад асуудал хэлэлцэх

36^{1.1}.Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан саналаа ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

36^{1.2}.Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргана.

36^{1.3}.Нэгдсэн хуралдаан шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороонд буцааж болно.

36^{1.4}.Байнгын хороо боловсруулан Улсын Их Хуралд оруулах зохион байгуулалтын шинжтэй асуудлыг энэ хуулийн 36^{1.1}-36^{1.3}-т заасан журмын дагуу хэлэлцэнэ.

36² дугаар зүйл.Цэцэд хүсэлт гаргах

36^{2.1}.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар гишүүн Цэцэд хүсэлт гаргах саналыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлбэл уг асуудлыг Хууль зүйн байнгын хороо ажлын 14 өдрийн дотор хуралдаанаараа хэлэлцэж саналд дурдсан асуудал нэг бүрээр санал хураан нэгдсэн хуралдаанд санал, дүгнэлтээ оруулна.

36^{2.2}.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 36^{2.1}-д заасан санал, дүгнэлт гарснаас хойш ажлын 7 өдрийн дотор хуралдаж асуудал нэг бүрээр Байнгын хорооны саналаар санал хураалт явуулах бөгөөд санал



хураалтаар олонхийн дэмжлэг авсан асуудлаар Цэцэд хүсэлт гаргахыг зөвшөөрсөн гэж үзнэ.

36².3. Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 36².2-т заасан асуудлаар хүсэлт гаргах тухай албан бичгийг Цэцэд хүргүүлнэ.

36³ дугаар зүйл. Цэцийн хуралдаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох, тайлбар гаргах

36³.1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг шийдвэрлэх хуралдаанд тайлбар авахаар ирүүлсэн Цэцийн албан бичгийг Улсын Их Хурлын дарга холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ.

36³.2. Холбогдох Байнгын хорооны дарга Цэцийн хуралдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох гишүүний талаархи саналаа Улсын Их Хурлын даргад оруулна.

36³.3. Улсын Их Хурлын дарга захирамж гаргаж итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилно.

36³.4. Итгэмжлэгдсэн төлөөлөгч тухайн маргаантай асуудлаар Цэцэд өгөх тайлбарыг бэлтгэхэд Байнгын хорооны дарга шаардлагатай гэж үзвэл энэ талаар Байнгын хорооны гишүүдийн саналыг авах, эсхүл Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж чиглэл өгч болно.

36⁴ дүгээр зүйл. Онц болон дайны байдал зарлах, цуцлах тухай асуудлыг хэлэлцэх

36⁴.1. Онц болон дайны байдал зарлах тухай асуудлыг Онц байдлын тухай хуулийн 5-7 дугаар зүйл, Дайны байдлын тухай хуулийн 5, 6 дугаар зүйлд заасныг тус тус баримтлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэнэ.

36⁴.2. Энэ хуулийн 36⁴.1-д заасан шийдвэрийн төсөлтэй холбогдон гарах бусад хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг энэ хуульд заасан хугацааг харгалзахгүйгээр хэлэлцэнэ.

36⁴.3. Онц болон дайны байдал зарлах тухай Ерөнхийлөгчийн зарлиг батлах, эсхүл хүчингүй болгох асуудлыг хэлэлцэхэд уг асуудлыг нэгдсэн хуралдаанд Ерөнхийлөгч танилцуулна.

36⁴.4. Онц байдал зарлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй гишүүд санаачлан Улсын



Их Хуралд өргөн мэдүүлсэн бол уг асуудлыг нэгдсэн хуралдаанд хууль санаачилсан гишүүн танилцуулж, энэ хуулийн 36¹.1-д заасан дэгийн дагуу хэлэлцэнэ.”

12/39¹ дүгээр зүйл:

“39¹ дүгээр зүйл.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг хэлэлцэх журам

39¹.1.Ерөнхий сайд эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан, түүнчлэн мөнхүү шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан Засгийн газрын гишүүний саналыг Улсын Их Хуралд оруулсан бол Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлыг 7 хоногийн дотор хэлэлцэн санал, дүгнэлт гаргана.

39¹.2.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 39¹.1-д заасан хүсэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор хэлэлцэн ил санал хураалт явуулах бөгөөд чөлөөлөгдөх хүсэлтийг нь хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай тогтоол батлагдсанд тооцно.

39¹.3.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх шалтгаан үндэслэлийн талаар гишүүд асуулт асууж, үг хэлж болно.”

13/40¹ дүгээр зүйл:

“40¹ дүгээр зүйл.Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг хэлэлцэх журам

40¹.1.Цэцийн гишүүн эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхийн хугацаа дуусахаасаа өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ Улсын Их Хуралд ирүүлсэн бол Хууль зүйн байнгын хороо энэ асуудлыг 7 хоногийн дотор хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд танилцуулна.

40¹.2.Нэгдсэн хуралдаанаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор хэлэлцэн ил санал хураалт явуулах бөгөөд чөлөөлөгдөх хүсэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай



тогтоол батлагдсанд тооцно.

40³.3.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх шалтгаан үндэслэлийн талаар гишүүд асуулт асууж, үг хэлж болно.”

14/43¹ дүгээр зүйл:

“43¹ дүгээр зүйл.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг тогтоох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх журам

43¹.1.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг тогтоох саналыг Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 7 хоногийн дотор хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

43¹.2.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Засгийн газраас зөвшилцөхөөр ирүүлсэн санал, танилцуулгыг хуралдаанаараа хэлэлцэж ил санал хураалт явуулж гишүүдийн олонхи дэмжсэн бол саналыг дэмжиж байгаагаа Засгийн газарт хариу мэдэгдэх ба ингэхдээ уг асуудлыг эцэслэн шийдвэрлэхэд анхаарвал зохих асуудлаар гишүүдийн гаргасан саналыг хавсаргана.

43¹.3.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг тогтоох тухай тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаан ил санал хураалт явуулж гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд энэ асуудлаар Улсын Их Хурал тогтоол батална.”

15/45 дугаар зүйлийн 45.5, 45.6 дахь хэсэг:

“45.5.Хуульд заасны дагуу албан тушаалд томилуулах саналыг Улсын Их Хурал, Байнгын хороо, Улсын Их Хурлын дарга гаргах, нэр дэвшүүлэх бол холбогдох хуульд заасан журам, шаардлага, шалгуурыг үндэслэнэ.

45.6.Байнгын хороо хуульд заасны дагуу албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэхдээ гишүүдээс санал болгосон нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар нэр дэвшүүлэхийг дэмжсэнд тооцно.”

16/47 дугаар зүйлийн 47.2.8 дахь заалт:

"47.2.8.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тайланг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо."

17/47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсэг:

"47.9.Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаархи мэдээллийг Авлигатай тэмцэх газар жил бүрийн эхний улиралд Улсын Их Хуралд мэдээлнэ."

18/53¹ дүгээр зүйл:

"53¹ дүгээр зүйл.Улсын Их Хурлын үйл ажиллагааг мэдээлэх журам

53¹.1.Улсын Их Хурлын үйл ажиллагааг телевизийн тусгай сувгаар шууд нэвтрүүлэх болон телевиз, радиод тусгай цаг гаргаж олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар зохион байгуулна.

53¹.2.Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах эрхийг ээлжит чуулган бүрийн эхэнд хэвлэл, мэдээллийн байгууллагаас ирүүлсэн санал, ажлын туршлага, мэргэжлийн ур чадварыг нь харгалзан хэвлэл, мэдээллийн ажилтны нэр зааж олгоно.

53¹.3.Энэ хуулийн 53¹.2-т заасан сурвалжлах эрхтэй хэвлэл, мэдээллийн ажилтан нь Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд заасан журмыг баримтлан Төрийн ордонд тусгайлан гаргасан өрөөнд байрлан үйл ажиллагаа явуулна.

53¹.4.Байнгын, дэд, түр хороо, нам, эвслийн бүлэг болон ажлын хэсгийн хуралдаан дууссаны дараа хуралдаан даргалагч нь хэвлэл, мэдээллийн ажилтанд мэдээлэл өгөх зориулалтын өрөөнд хуралдааны талаар мэдээлэл хийж болох бөгөөд хуралдаанд хэлэлцэж байгаа асуудлаар цөөнх болсон гишүүдийг төлөөлж нэг гишүүн байр сууриа хэвлэл, мэдээллийн ажилтнуудад мэдээлэл өгөх зориулалтын өрөөнд мэдээлэл өгч болно."

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийн "хуралдаанаар хэлэлцэж" гэсний дараа "ажлын хэсэгт орсон Улсын Их Хурлын гишүүдийн дунд санал хураалт явуулж" гэж, 23 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтын "чиглэл" гэсний дараа "хуралдаан даргалагчаас" гэж, мөн зүйлийн 23.7



дахь хэсгийн "бэлтгэх" гэсний дараа "болон энэ хуулийн 23.5, 24.6-д заасан төслийг боловсруулах" гэж, 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийн "болон" гэсний дараа "энэ хуулийн 23.5-д заасан" гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт "Засгийн газар төсвийг зохиоходоо Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх/ болон Үндсэн чиглэлтэй нийцүүлнэ." гэсэн хоёр дахь өгүүлбэр, мөн зүйлийн 25.6 дахь хэсэгт "Үндсэн чиглэлийг хэлэлцэхэд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад хүмүүс байлцана." гэсэн хоёр дахь өгүүлбэр, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн "байнгын хороо" гэсний дараа "уг асуудлыг ажлын 5 өдрийн дотор" гэж, 34.2 дахь хэсгийн "дүгнэлтийг" гэсний дараа "ажлын 5 өдрийн дотор" гэж, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн "байнгын хороо" гэсний дараа "ажлын 5 өдрийн дотор" гэж, мөн зүйлийн 40.2 дахь хэсгийн "Нэгдсэн хуралдаан" гэсний дараа "Хууль зүйн байнгын хорооны дүгнэлт гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор хуралдаж" гэж, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн "таригийн" гэсний дараа "15 цагаас" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг:

"7.1.Нэгдсэн хуралдаанаас бусад нээлттэй хуралдаанд зөвхөн хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтнууд, Тамгын газрын ажилтнууд болон гишүүдийн зөвлөх, туслахууд оролцож болно."

2/8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт:

"8.1.7.асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд нэмэлт хариулт, тайлбар хангалтгүй гэж үзвэл тухайн гишүүний саналаар 2 хүртэл удаа тус бүр 1 минутаас илүүгүй хугацаагаар дахин нэмэлт асуулт асууж тайлбар авах."

3/8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг:

"8.4.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл хэлэлцэхэд тухайн төслийн талаархи хууль санаачлагчийн илтгэл, холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонссоны дараа тэдгээртэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуух асуултыг тэдгээрийн нэрсээ ирүүлсэн дарааллыг нь баримтлан



хуралдаан даргалагч зохицуулна.”

4/8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг:

“8.6.Хуралдаанд төсөл хэлэлцэхэд зөвхөн тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эсхүл түүнийг орлож байгаа Засгийн газрын гишүүн гишүүдийн асуултад хариулах буюу тайлбар хийнэ. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон, түүнчлэн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон уригдаж ирсэн хүмүүс хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр тайлбар хийж асуултад хариулж болно.”

5/11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг:

“11.2.Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн тангараг өргөх ёслол үйлдэж дуустал Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргыг сонгож дуустал Улсын Их Хурлын насаар хамгийн ахмад гишүүн чуулганы хуралдааныг зохион байгуулж даргална.”

6/16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг:

“16.3.Төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь дэмжсэн бол төслийг анхны хэлэлцүүлгээр батлах боломжтой гэсэн санал, дүгнэлтийг гаргаж нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи уг горимын саналыг дэмжсэн бол төслийг анхны хэлэлцүүлгээр баталж болох бөгөөд хэрэв олонхи дэмжээгүй бол эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр санал хураалт явуулахгүйгээр холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ.”

7/18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг:

“18.2.Энэ хуулийн 18.1-д заасны дагуу төсөл, түүнд хавсаргасан баримт бичгийг холбогдох Байнгын хороонд шилжүүлснээс хойш 3 хоногийн дотор нийт гишүүдэд хувилж хүргүүлнэ.”

8/46 дугаар зүйл:

**“46 дугаар зүйл.Засгийн газрын үйл ажиллагааны
хөтөлбөрийн болон Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг
хэлэлцэх журам**

46.1.Хөтөлбөр болон Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

46.2.Хөтөлбөр болон Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг Улсын Их Хурал дараа жилийн Үндсэн чиглэлийг хэлэлцэж эхлэхээс өмнө хэлэлцсэн байна.

46.3.Засгийн газар Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг зорилт, арга хэмжээ тус бүрээр гаргасан байна.

46.4.Хөтөлбөр болон Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд оруулна.

46.5.Нам, эвслийн бүлэг, Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хөтөлбөр, Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хуралдаанаараа хэлэлцсэн бол гаргасан санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

46.6.Нэгдсэн хуралдаан Ерөнхий сайдын илтгэл, Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, хөтөлбөр, Үндсэн чиглэлийн биелэлтийн тухай тогтоол батална.

46.7.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад албан тушаалтан, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно."

9/48 дугаар зүйлийн 48.8 дахь хэсэг:

"48.8.Ерөнхий сайдыг тодорхой сэдвээр мэдээлэл хийх шаардлагагүй гэж үзвэл мэдээллийн цагт энэ хуулийн 48.1-д дурдсан сэдвийн хүрээнд гишүүдийн тавьсан асуултад шууд хариулт өгөх ажлыг зохион байгуулж болно."

4 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн "үдээс хойш 15 цагаас эхэлнэ." гэснийг "эхэлж, үдээс хойш 15 цагаас үргэлжилнэ." гэж, мөн зүйлийн 4.3 дахь хэсгийн "тус тус зохион байгуулна." гэснийг "шаардлагатай бол энэ хуулийн 4.2-т заасан журмыг баримтлан бусад ажлын өдөрт зохион байгуулж болно." гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн "Хаалттай" гэснийг "Энэ хуулийн 5.1-д заасан хаалттай" гэж, 16¹ дүгээр зүйлийн 16² дахь хэсгийн "18.2-т" гэснийг "18.2, 28.2-т" гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн "холбогдох болон Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэх нь зүйтэй гэсэн санал, дүгнэлт гаргасан бол нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж" гэснийг "Улсын Их Хурлын дарга



Зөвлөлтэй зөвшилцөн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж” гэж, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “хууль болон хуулийн” гэснийг “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр болон төслийн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3 дахь хэсгийн “санал хураалгах” гэснийг “зарчмын зөрүүтэй саналын” гэж, мөн зүйлийн 21.10 дахь хэсгийн “хураалгах бөгөөд тэгэхдээ энэ хуулийн 21.8-д заасан таслах эрх эдэлнэ.” гэснийг “хураалгана.” гэж, 23 дугаар зүйлийн 23.2.3 дахь заалт, мөн зүйлийн 23.5 дахь хэсгийн “дэмжигдсэн” гэснийг “санал хурааж шийдвэрлэсэн” гэж, 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийн “энэ хуульд заасан” гэснийг “мөн хуулийн 21-24 дүгээр зүйлд заасан” гэж, 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсгийн “Нэгдсэн хуралдаан мөнгөний бодлогын баримт бичгийн анхны хэлэлцүүлэг явуулсны дараа төсвийн” гэснийг “Төсвийн” гэж, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын тогтоолын” гэснийг, мөн зүйлийн 33.2 дахь хэсгийн “тогтоолын” гэснийг “хуулийн” гэж, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн, мөн зүйлийн 37.7 дахь хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “батална” гэснийг “батлагдсанд тооцно” гэж, 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсгийн “хэлэлцэх бөгөөд энэхүү үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулна.” гэснийг “хэлэлцэх бөгөөд шаардлагатай бол Баасан гаригийн үдээс өмнөх хуралдаанд хэлэлцэж болно.” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “төслийг” гэсний өмнөх “хуулийн” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсгийн “хууль санаачлагчаас асуулт асууж,” гэснийг, мөн зүйлийн 21.18 дахь хэсгийн “болон нээлттэй хуралдаанаар хэлэлцүүлэх” гэснийг, 29 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 29.1 дэх хэсгийн “олон талт” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.8, 21.9, 21.16, 21.17 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.3.4 дэх заалт, 35 дугаар зүйл, 43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг:

"3.2.Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь хараат бус, нээлттэй, ил тод, хариуцлагатай, иргэдэд хүртээмжтэй байх бөгөөд асуудлыг тал бүрээс нь хэлэлцэж цөөнхийн саналыг хүндэтгэн үзэж олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд тулгуурлана."

2/11 дүгээр зүйлийн 11.1.21 дэх заалт:

"11.1.21.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх санал гаргаж Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх;"

3/15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг:

"15.4.Энэ хуулийн 15.1-д заасан чуулганы хугацааг шаардлагатай бол Улсын Их Хурлын дарга 14 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болох бөгөөд энэ тухай захирамж гаргана."

4/20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт:

"20.1.7.цөмийн энерги ашиглах, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах бодлого;"

5/20 дугаар зүйлийн 20.2.17, 20.2.18 дахь заалт:

"20.2.17.газрын сангийн нэгдсэн бодлого, зохицуулалт;
20.2.18.газрын кадастр, зураглал."

6/20 дугаар зүйлийн 20.3.11 дэх заалт:

"20.3.11.жендерийн тэгш байдлыг хангах бодлого."

**7/20 дугаар зүйлийн 20.5.6 дахь заалт:**

"20.5.6.төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор Засгийн газраас гаргах үнэт цаасны тухай асуудал."

8/20 дугаар зүйлийн 20.7.26 дахь заалт:

"20.7.26.газрын эдийн засгийн үр ашгийн бодлого."

9/21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсэг:

"21.8.Байнгын хороо энэ хуулийн 21.5-д заасан тогтоолын төслийг хуралдаанаараа хэлэлцэн батална."

10/24 дүгээр зүйлийн 24.3.9, 24.3.10 дахь заалт:

"24.3.9.Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо нь Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын асуудлыг;

24.3.10.Өргөдөл, гомдлын дэд хороо нь иргэд, байгууллагаас Улсын Их Хурал, гишүүнд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хянан шийдвэрлэх асуудлыг."

11/29 дүгээр зүйлийн 29.14 дэх хэсэг:

"29.14.Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг товлон зарласан үед Улсын Их Хурлын дарга Зөвлөлийн саналыг харгалзан чуулганыг 30 хүртэл хоногийн хугацаагаар түр завсарлуулж болно."

12/42¹ - 42³ дугаар зүйл:**"42¹ дүгээр зүйл.Улсын Их Хурлын төсөв**

42¹.1.Улсын Их Хурал бие даасан төсөвтэй байна.

42¹.2.Улсын Их Хурлын төсөв нь гишүүд, Байнгын хороод, нам, эвслийн бүлэг, Тамгын газар, Улсын Их Хурлын нийтлэг арга хэмжээний төсвөөс тус тус бүрдэнэ.

42¹.3.Улсын Их Хурлын төсөв нь түүний үйл ажиллагаагаар хэвийн явуулахад хүрэлцэхүйц хэмжээтэй байна.

**42³ дугаар зүйл. Улсын Их Хурлын төсвийг боловсруулах,
хэлэлцэх**

42³.1. Улсын Их Хурлын төсвийг Тамгын газар боловсруулах ба Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс тус тусын төсөвтэй холбогдсон саналыг авна.

42³.2. Тамгын газар Улсын Их Хурлын төсвийн төслийг энэ хуулийн 11.3-т заасан Зөвлөлтэй зөвшилцсөний дараа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

42³.3. Тамгын газар Улсын Их Хурлын төсвийн төслийг Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж гаргасан саналыг тусгаж, төсвийн эцсийн хувилбарыг улсын төсвийн төсөлд нэгтгүүлэхээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлнэ.

42³.4. Засгийн газар Улсын Их Хурлын төсвийн төслийг улсын төсвийн төсөлд бүрэн тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүж батлуулна.

42³.5. Засгийн газар Улсын Их Хурлын төсвийн төсөлд өөрчлөлт оруулах санал гаргасан тохиолдолд уг саналыг улсын төсвийг чуулганаар хэлэлцэх үед хэлэлцэн шийдвэрлэнэ.

**42³ дугаар зүйл. Улсын Их Хурлын төсвийг зарцуулах,
гүйцэтгэлд тавих хяналт**

42³.1. Улсын Их Хурлын төсвийг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга зориулалтын дагуу захиран зарцуулна.

42³.2. Улсын Их Хурал жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлнэ. Төрийн аудитын төв байгууллага тайланг хүлээн авснаас хойш 1 сарын дотор тайлангийн талаар аудитын дүгнэлт гаргана.

42³.3. Улсын Их Хурлын төсвийн гүйцэтгэлийн тайлан, энэ хуулийн 42³.2-т заасан төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэнэ."

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтын "хангах" гэсний дараа, нэгдсэн хуралдааныг даргалах" гэж, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийн "зохицуулах," гэсний дараа "нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын санал болон хууль санаачлагчаас



өргөн мэдүүлсэн хугацааг харгалзан” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалтын “томилох” гэсний дараа “, эгүүлэн татах” гэж, мөн зүйлийн 20.3.3 дахь заалтын “нийгмийн” гэсний дараа “халамж,” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.3 дахь заалтын “байдлын” гэсний дараа “, Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын, Өргөдөл, гомдлын” гэж, мөн зүйлийн 24.6 дахь хэсгийн “халдашгүй байдлын” гэсний дараа “болон Ёс зүйн, Өргөдөл, гомдлын” гэж, 35 дугаар зүйлийн 35.4, 35.10 дахь хэсгийн “туслах” гэсний өмнө “зөвлөх,” гэж, 41 дүгээр зүйлийн 41.1.4 дэх заалтын “пишүүний” гэсний дараа “саналыг үндэслэн түүний зөвлөх,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг:

“3.1.Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчим бол Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ёсоор ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал мөн.”

2/15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг:

“15.1.Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган 10 дугаар сарын 1-ний өдрөөс дараа оны 2 дугаар сарын 10-ны хооронд, хаврын ээлжит чуулган 4 дүгээр сарын 5-ны өдрөөс мөн оны 7 дугаар сарын 1-ний хооронд тус тус хуралдана. Хэрэв ээлжит чуулганыг нээх, хаах өдрүүд амралт, баяр ёслолын өдөртэй давхацвал ажлын дараагийн өдөр тус тус нээж, хаана.”

3/20 дугаар зүйлийн 20.4.9 дэх заалт:

“20.4.9.төрийн ба төрийн бус байгууллага, улс төрийн намтай харилцах,”

4/20 дугаар зүйлийн 20.6.15 дахь заалт:

“20.6.15.иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл,”

5/20 дугаар зүйлийн 20.7.5 дахь заалт:

“20.7.5.даатгалын бодлого, энэ хуулийн 20.5.6-д зааснаас бусад үнэт цаасны тухай асуудал,”

6/20 дугаар зүйлийн 20.12 дахь хэсэг:

“20.12.Байнгын хороо нь эрхлэх асуудлын хүрээнд хамаарах



асуудлаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, судалгаа, мэдээллээр хангах, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын албатай байна.”

7/27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг:

“27.2.Бүлэг нь бодлогоо боловсруулах, зохион байгуулалтын туслалцаа авах чиг үүрэг бүхий ажлын албатай байх бөгөөд түүний гүйцэтгэх үүргийг нь бүлгийн дүрмээр зохицуулна. Ажлын албыг хоёр гишүүнд нэг ажилтан ногдохоор тооцон бүрдүүлнэ.”

8/33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг:

“33.2.Төр, нийгмийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзвэл уг асуудлаар Засгийн газрын байр суурийг тодруулах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг шаардаж гишүүнээс энэ хуулийн 33.1.2-т заасан албан тушаалтанд бичгээр хандсаныг “асуулга” гэнэ.”

9/33 дугаар зүйлийн 33.13 дахь хэсэг:

“33.13.Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид энэ хуулийн 33.11-д дурдсан ажлын хэсэг хяналт шалгалт явуулах шаардлага гарвал шалгалтыг төрийн хяналт шалгалтын эрх бүхий байгууллагатай хамтарч гүйцэтгэн дүнг Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.”

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тогтоолыг Улсын Их Хурал баталсан” гэснийг “гишүүн сонгогдож, Улсын Их Хурлын гишүүний тангараг өргөсөн” гэж, 6 дугаар зүйлийн 6.6.4 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.2.3 дахь заалтын “гарсан” гэснийг “гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан” гэж, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “гомдлыг” гэснийг “гомдол болон хууль тогтоомжийн хэрэгжилт, бусад асуудлаар ирүүлсэн албан бичгийг” гэж, мөн хэсгийн “хуульд заасан” гэснийг “30 хоногийн” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “эвслийн бүлгийг” гэснийг “эвслийг” гэж, мөн зүйлийн 8.2 дахь хэсгийн “эвслийн бүлэг,” гэснийг “эвсэл,” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын” гэснийг “энэ хуулийн 11.3-т заасан Зөвлөлийн” гэж, мөн зүйлийн 11.1.13 дахь заалтын “нам, эвслийн бүлэг, Байнгын хорооны” гэснийг “Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн” гэж, мөн зүйлийн 11.1.16 дахь заалтын “хуульд заасан бол” гэснийг “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, мөн зүйлийн 11.1.21 дэх заалтын дугаарыг “11.1.22.” гэж, мөн зүйлийн 11.3



дахь хэсгийн "төсвийн төслийн талаар санал оруулах," гэснийг "төсөв болон" гэж, мөн зүйлийн 11.6 дахь хэсгийн "чиглэлийг" гэснийг "чиглэл, дарааллыг" гэж, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн "чөлөөлж" гэснийг "чөлөөлөгдсөнд тооцож" гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн "намын" гэснийг "нам, эвслийн" гэж, 14 дүгээр зүйлийн 14.3.3 дахь заалтын "тэдгээрийн" гэснийг "Байнгын хорооны" гэж, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн "цагийг" гэснийг "цаг, үргэлжлэх хугацааг" гэж, 20 дугаар зүйлийн 20.3.1 дэх заалтын "хүн амын" гэснийг "хүн ам, хөгжлийн" гэж, мөн зүйлийн 20.3.10 дахь заалтын "соёл, урлаг, ёс заншлын талаар төрөөс баримтлах бодлого" гэснийг "ёс заншил" гэж, 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн "гишүүнээр" гэснийг "гишүүнд" гэж, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн "харьяалах" гэснийг "харьяалагдах" гэж, мөн зүйлийн 24.7 дахь хэсгийн "дөрвөн" гэснийг "таван" гэж, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтын "гарч" гэснийг "гарахад" гэж, 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсгийн "хариулах, тайлбар хийх, байр сууриа илэрхийлнэ" гэснийг "хариулан байр сууриа илэрхийлж болно" гэж, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтын "Засгийн газар" гэснийг "Засгийн газрын" гэж, мөн зүйлийн 33.7 дахь хэсгийн "сонирхлыг хөндсөн" гэснийг "сонирхол хөндөгдсөн гэж үзвэл" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 хэсгийн ", 6.6.2" гэснийг, мөн зүйлийн 6.11, 6.12, 6.15 дахь хэсгийн ", 6.9.2" гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.21 дэх заалтын "өвчтэй хүн асрах," гэснийг, 20 дугаар зүйлийн 20.3.2 дахь заалтын "хүн амын" гэснийг, 24 дүгээр зүйлийн 24.9 дэх хэсгийн "болон Ёс зүйн" гэснийг, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн "Зөвлөлийн саналыг харгалзан" гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн "холбогдох Байнгын хорооны даргын саналыг харгалзан" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2, 6.9.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.7.8 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1.6 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.14 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УПСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

ДДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 дугаар
сарын 31-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг байгуулж, байршил, нутаг дэвсгэрийн харъяаллыг дор дурдсанаар тогтоосугай.

Шүүхийн нэр	Байрших газрын нэр	Нутаг дэвсгэрийн харъяалал
Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар
хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2006 оны 56 дугаар тогтоолоор баталсан "Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн ажиллах журам"-ын 6.1 дэх заалтыг "Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд олгох урамшууллын хэмжээг Хяналтын зөвлөлийн ажилд оролцсон байдлыг нь харгалзаж, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороотой зөвшилцөн Санхүүгийн зохицуулах хороо тогтооно." гэж өөрчлөн найруулсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар
хот

Доминиканы Бүгд Найрамдах Улстай дипломат харилцаа тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Доминиканы Бүгд Найрамдах Улстай дипломат харилцаа тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

Шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээг тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийг
үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах
тухай хууль батлагдсантай холбогдуулж тус шүүхийн шүүгчийн орон тоог
Ерөнхий шүүгч 1, шүүгч 6 байхаар тогтоосугай.

2.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий
шүүгчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг 716789 төгрөгөөр,
шүүгчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг 659490 төгрөгөөр тус
тус тогтоосугай.

3.Энэ тогтоолыг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн
дагаж мөрдөхөөр тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 270

Улаанбаатар
хот

Зарим хүнийг Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.4,
32.6 дахь хэсэг, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүрсэн саналыг тус
тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тумагийн Цэцэгмааг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн
Ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан, Сүхбаатарын Сэржмядагийг
Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн албан
тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 271

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.4 дэх заалт, 58.2 дахь хэсэгт зааснаар Шүүхийн Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн Нямдоржийн Ичинхорлоог Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 10 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 272

Улаанбаатар
хот

"Эрдэнэс-Тавантолгой" ХК байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалт, Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийг "Эрдэнэс МГЛ" ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулсугай.

2. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай:

2.1. Компанийн өөрийн хөрөнгийг бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн толгой компани болох "Эрдэнэс МГЛ" ХХК-ийн хөрөнгөөс гаргах.

2.2. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн дүрмийг яамдаас өгсөн саналыг тусгасны үндсэн дээр зохих журмын дагуу баталж мөрдүүлэх.

3. Дараахь ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн хороо (Д.Сугар), "Эрдэнэс МГЛ" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Энэбиш нарт даалгасугай:

3.1. "Эрдэнэс-Тавантолгой" компанийн хувьцааны 10 хувийг Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх, 10 хувийг үндэсний аж ахуйн нэгжүүдэд нэрлэсэн үнээр худалдах, 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн бирж дээр арилжаалахдаа хувьцааны үнэ, тоо, нөхцөл болон компанийн үнэлгээтэй холбоотой асуудлыг боловсруулж Засгийн газарт тухай бүр танилцуулан шийдвэрлүүлж байх.

3.2. Компанийн хувьцааг гадаад, дотоодын хөрөнгийн биржид арилжаалах бэлтгэл ажлыг эхлүүлж, шаардлагатай олон улсын зөвлөх компани, аудитор, хөрөнгө оруулалтын банкнийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж хамтран ажиллах.

4. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг үнэ төлбөргүй эзэмших иргэд болон компанийн хувьцааг нэрлэсэн үнээр худалдаж авах эрх бүхий үндэсний аж ахуйн нэгжийн тоог тодорхой болгох ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

5. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг эзэмшүүлэх, нэрлэсэн үнээр худалдаалах, бирж дээр арилжаалах болон компанийн үнэлгээ хийлгэх асуудлыг олон нийтад нээлттэй, ил тод байлгах арга хэмжээ авч, ажлын явцын талаар тогтмол танилцуулж байхыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар, Эрдэнэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 10 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 275

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.26 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, "Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Үндэсний хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тухайн жилийн төсвийн төсөлд тусгах, хувийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансар, Харилцаа холбооны зохицуулах хороо (Б.Болдбаатар)-нд даалгасугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2010 оны 275 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙГ ТООН ТЕХНОЛОГИД ШИЛЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсад аналог радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн системийг тоон технологид үе шаттай шилжүүлэхэд баримтлах бодлого, зохицуулалтын арга хэмжээг тодорхойлох, тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг бэлтгэх, дамжуулах, хүлээн авах боломжийг бүрдүүлэх цогц арга хэмжээ, хэрэгжүүлэх үйл ажиллагааг энэхүү үндэсний хөтөлбөрт тусгав.

2006 онд хуралдсан Олон улсын цахилгаан холбооны байгууллагын (International Telecommunication Union) Радиогийн Их Хурлаас 2015 он хүртэлх хугацаанд дэлхийн улсуудыг радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн сүлжээ, үйлчилгээг тоон технологид шилжүүлэх шийдвэр (GE-06) гаргасан. Өнөөгийн байдлаар гадаадын 10 гаруй орон аналог радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг бүрэн зогсоож, тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлэгт шилжсэн бөгөөд Европын бүх орон 2015 онд, Ази, Номхон далайн бүсийн орнуудаас Австрали Улс, Япон Улс, БНСУ, БНХАУ-ын Гонконг, Тайвань, Малайз Улс, Шинэ Зеланд Улс, Филиппин Улс 2013 онд аналог өргөн нэвтрүүлгийн сүлжээг бүрэн зогсоохоо албан ёсоор зарласан байна.

Олон улсын байгууллагын шийдвэр, зөвлөмжүүд, гадаад орнуудын туршлага, радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, сүлжээний техник технологийн хөгжлийн хандлага болон Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.26-д "Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлж, телевизийн олон сувгийг орон даяар хүлээн авах боломжийг бүрдүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

Хөтөлбөрт хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1. "Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн систем" гэж радио,



телевизийн нэвтрүүлэг бэлтгэх болон боловсруулах студи, түүнийг дамжуулах, түгээх сүлжээ, нэвтрүүлгийг хүлээн авах хэрэглэгчийн төхөөрөмжийг.

2.2. "Хэрэглэгчийн төхөөрөмж" гэж радио, телевизор болон хэрэглэгч тоон нэвтрүүлгийг хүлээн авч үзэхэд шаардлагатай бусад хувиргагч төхөөрөмжийг.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрийн хамрах хүрээ, бүрэлдэхүүн

3.1 Хөтөлбөрийн үндсэн зорилго нь Монгол Улсад радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн системийг тоон технологид бүрэн шилжүүлэх замаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй болгож, мэдээлэл, харилцаа холбооны шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлж, хэрэглээг нэмэгдүүлэхэд оршино.

3.2. Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөрт Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх радио, телевиз, тэдгээрийн нэвтрүүлэх станц, дамжуулах байгууламж, хүлээн авах болон хэрэглэгчийн төхөөрөмж, төсөл, хөтөлбөр хамаарна.

Дөрөв. Хэрэгжүүлэх үндсэн зарчмууд

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь үндсэн зарчмыг баримтална:

4.1. Мэргэжлийн холбоод, холбогдох төрийн бус байгууллага, төрийн болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагын оролцоо, идэвх санаачилгад тулгуурлах.

4.2. Төр-хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурлах.

4.3. Иргэдийн идэвх, оролцоог дээшлүүлэх;

4.4. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний ач холбогдол, үр өгөөжийг олон нийтэд сурталчлах.

4.5. Мэргэжлийн боловсон хүчний мэдлэг, чадавхийг дээшлүүлэх.



Тав. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх дараахь зорилтуудыг дэвшүүлж байна:

5.1. Нэгдүгээр зорилт: Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх.

5.2. Хоёрдугаар зорилт: Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системд шилжүүлэх техник, технологийн шийдлийг боловсруулах.

5.3. Гуравдугаар зорилт: Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системд шилжүүлэх ажлыг нэгдсэн төлөвлөлтийн дагуу газар зүйн хувьд хэсэгчлэн үе шаттайгаар зохион байгуулах.

5.4. Дөрөвдүгээр зорилт: Хөтөлбөрийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сурталчлах, сургалт зохион байгуулах.

Хөтөлбөрийн зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.5. Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системд шилжүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэх нэгдүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.5.1. тоон радио, телевизийн олон улсын хөгжлийн чиг хандлага, мөрдөгдөж байгаа стандарт, ангилал, сүлжээний бүтцийн талаар судалгаа хийсний үндсэн дээр Монгол Улсад мөрдөх тоон радио, телевизийн стандарт, сүлжээний загварыг сонгож батлан мөрдүүлэх;

5.5.2. тоон радио, телевизийн системд шилжихэд баримтлах бодлого, чиглэл боловсруулан батлуулах;

5.5.3. тоон радио, телевизийн системд шилжихтэй холбогдсон зохицуулалтын журам боловсруулах;

5.5.4. тоон радио, телевизийн тоног, төхөөрөмжид тавигдах техникийн нөхцөл, шаардлагыг боловсруулах;

5.5.5. тоон радио, телевизэд ашиглах радио давтамжийн зурвасын төлөвлөлт, хуваарилалт хийх;

5.5.6. бусад.



Хүрэх үр дүн: Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх эрх зүй, зохицуулалтын орчин бүрдэнэ.

5.6. Тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн системийг бий болгох техник, технологийн шийдлийг боловсруулах хоёрдугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.6.1. тоон радио, телевизийн үйлчилгээг дамжуулахтай холбогдсон бэлтгэл ажлыг хангах, газрын тоон сүлжээг зохион байгуулах:

а) тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн дамжуулах станцад тавигдах техникийн нөхцөл, шаардлагыг тодорхойлох;

б) шилжилтийн үе шатанд аналог өргөн нэвтрүүлгийн системд баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлох;

в) аймгийн төв, томоохон сум, суурин газарт хүргэх дэд бүтэц, дахин дамжуулах тоон технологийн сүлжээний загвар гаргах;

г) тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг дамжуулах сүлжээ байгуулах нэгдсэн хуваарийг хийх;

д) тоон радиогийн сүлжээний загвар болон хуваарийн дагуу аймгийн төв, томоохон сум, суурин газарт дэд бүтэц, дамжуулах сүлжээг байгуулах.

5.6.2. тоон радио, телевизийн үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбогдсон бэлтгэл ажлыг хангах, тоон студийг байгуулах арга хэмжээ авах:

а) сонгосон стандартад нийцүүлэн студийн тоног төхөөрөмжийг шинэчлэхтэй холбогдсон дэвшилтэт техник, технологийн судалгаа хийх;

б) студийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, тоон системээр дамжуулах боломжийг бүрдүүлэх нэгдсэн хуваарь хийх;



в) тоног төхөөрөмжид тавигдах техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, баталгаажуулалтын тогтолцоог бий болгох.

5.6.3. тоон радио, телевизийн үйлчилгээг хүлээн авахтай холбогдсон бэлтгэл ажлыг ханган, шаардагдах судалгаа хийж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах:

а) тоон радио, телевизортой болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг шинээр худалдан авах өрхийн судалгааг гаргах;

б) тоон телевизорын хэрэглэгчийн хувиргагч төхөөрөмж (set top box)-ийг худалдан авахад төрөөс зохих журмын дагуу дэмжлэх үзүүлэх;

в) хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн нөхцөл, шаардлагыг тогтоож, тэдгээрийн баталгаажуулалтын тогтолцоог бий болгох.

5.6.4. Монгол Улсад газрын сүлжээний телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үе шатыг тодорхойлж, тоон радио, телевизийн системд шилжих нэгдсэн төлөвлөлт хийх.

Хүрэх үр дүн: Монгол Улсад тоон радио, телевизийн үйлчилгээ явуулах техник, технологийн боломж бүрдэж, тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн системд шилжих нэгдсэн төлөвлөлт бий болно.

5.7. Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системд шилжүүлэх ажлыг нэгдсэн төлөвлөлтийн дагуу газар зүйн хувьд хэсэгчлэн үе шаттайгаар зохион байгуулах гуравдугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.7.1. газрын сүлжээний тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн туршилтын төсөл боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.7.2. радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг аналог болон тоон хэлбэрээр нэгэн зэрэг ажиллуулах болон тоон технологид шилжүүлэх үйл ажиллагааг газар зүйн хувьд хэсэгчлэн, үе шаттайгаар нэгдсэн төлөвлөлтийн дагуу удирдан зохион байгуулж хэрэгжүүлэх;



5.7.3. Монгол Улсад аналогич технологи ашиглан радио, телевизийн өргөн нэвтрүүлэг дамжуулах сүлжээний үйл ажиллагааг 2014 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 00 цагт бүрэн зогсоож тоон технологийн системийг ашиглаж эхлэх

5.7.4. бусад.

Хүрэх үр дүн: Монгол Улс нь радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн тоон системд нэгдсэн төлөвлөлтийн дагуу шилжинэ.

5.8. Төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сурталчлах, сургалт зохион байгуулах дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.8.1. радио, телевизийн тоон системд шилжих арга хэмжээнд олон нийтийг бүрэн хамруулж, холбогдох төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

5.8.2. радио, телевизийн тоон системд шилжсэн гадаад орны туршлага судлах, гадаад, дотоодын зөвлөх үйлчилгээ авах;

5.8.3. холбогдох заавар, зөвлөмж боловсруулан баталж тэдгээрийг нийтэд сурталчлах;

5.8.4. радио, телевизийн тоон системд шилжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулж давхардсан хөрөнгө оруулалтаас зайлсхийх, энэ чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлын талаархи мэдээллийг нэгтгэх;

5.8.5. радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн тоон системийн чиглэлээр ажиллах мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, сургалт зохион байгуулах;

5.8.6. иргэдийн дунд радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн тоон системд шилжих талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

5.8.7. хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар уулзалт, зөвлөлтөөн зохион байгуулах;



Хүрэх үр дүн: Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоо, хамтын ажиллагаа идэвхжин радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн тоон технологид шилжих талаар зохих мэдлэгтэй болж, холбогдох мэдээллээр хангагдана.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хугацаа

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, оролцогч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, явцыг Засгийн газарт тайлагнах асуудлыг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар хариуцна.

6.2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагч орон болон холбогдох төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдийн дэмжлэгийг авч ажиллана.

6.3. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

6.3.1. төсвийн хөрөнгө;

6.3.2. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, тусламж;

6.3.3. бусад эх үүсвэр.

6.4. Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн тоон технологид шилжих үйл ажиллагааны хүрээнд Концессын тухай хуулийн дагуу төр-хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.

6.5. Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх Үндэсний хөтөлбөрийг 2010-2015 онд хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар нь үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаархи мэдээллийг нэгтгэн цуглуулж бодлогын дүн шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнгийн тайлан, үнэлгээг Засгийн газарт танилцуулах, нийтэд мэдээлэх, тайлагнах чиг үүргийг гүйцэтгэнэ.



Засгийн газрын 2010 оны 275 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙГ ТООН ТЕХНОЛОГИД
ШИЛЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хөтөлбөрийн зорилт	Үйл ажиллагааны хүрээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хөрөнгө /сая.төг/	Эх үүсвэр
		1.1. Тоон радио, телевизийн олон улсын хөгжлийн чиг хандлага, мөргөлдөж сайгаа стандарт, ангилал, сүлжээний бүтцийн талаар судалгаа хийсэний үндсэн дээр Монгол Улсад мөрдөх тоон радио, телевизийн стандарт, сүлжээний загварыг сонгож батлан мөрдүүлэх	2010-2011	МШХХТГ, Харилцаа холбооны зохицуулах хороо	5.0	Харилцаа холбооны зохицуулах хорооны санхүүжилт
1	Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх	1.2. Тоон радио, телевизийн системд шилжихтэй холбогдоон зохицуулалтын журам боловсруулах 1.3. Тоон радио, телевизийн тоног төхөөрөмжид тавигдах техникийн нөхцөл шаардлагыг боловсруулж мөрдүүлэх	2010-2011	Харилцаа холбооны зохицуулах хороо	-	-
		1.4. Тоон радио, телевизэд ашиглах радио давтамжийн зурвасын төлөвлөлт, хуваарилалтыг хийх	2010-2011	МШХХТГ, Харилцаа холбооны зохицуулах хороо	5.0	Харилцаа холбооны зохицуулах хорооны санхүүжилт
			2010-2011	Харилцаа холбооны зохицуулах хороо	-	-



		<p>2.1. Тоон радио телевизийн өргөн нэвтрүүлгийн дамжуулах станцад тавигдах төхөөрөлийн нөхцөл, шаардлагыг тодорхойлох</p> <p>2.2. Шилжилтийн үе шатны үед аналэг өргөн нэвтрүүлгийн системд баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлох</p> <p>2.3. Аймгийн төв, Томоохон сум, суурин газарт дад бүтээх дахин дамжуулах тоон технологийн сүлжээний загвар гаргах</p> <p>2.4. Радио телевизийн өргөн нэвтрүүлгийг дамжуулах тоон сүлжээ байгуулах нэгдсэн хуваарийг хийх</p> <p>2.5. Тоон телевизийн сүлжээний загвар болон хуваарийн дагуу аймгийн төв, томоохон сум, суурин газарт дад бүтээх дамжуулах сүлжээг байгуулах</p> <p>2.6. Тоон радиогийн сүлжээний загвар болон хуваарийн дагуу аймгийн төв, Томоохон сум, суурин газарт дад бүтээх дамжуулах сүлжээг байгуулах</p>	<p>2010-2011</p> <p>2010-2011</p> <p>2010-2011</p> <p>2010-2011</p> <p>2011-2015</p> <p>2011-2015</p>	<p>МШХХТГ, Харилцаа холбооны зохицуулах хороо</p> <p>МШХХТГ, Харилцаа холбооны зохицуулах хороо</p> <p>МШХХТГ</p> <p>МШХХТГ, Харилцаа холбооны зохицуулах хороо</p> <p>МШХХТГ, Мэдээлэл холбооны сүлжээ ХХХ</p> <p>МШХХТГ</p>	<p>5.0</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>10,000.0</p> <p>23,000.0</p>	<p>Харилцаа холбооны зохицуулах хорооны санхүүжилт</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>Улсын төсөв</p> <p>Гадаадын ээл, тусламж</p>
2	<p>Тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системд шилжүүлэх төхөөрөлийн шийдлийг боловсруулах</p>					

<p>2.7. Сонгоон стандартад нийцүүлэн студийн тоног төхөөрөмжийг шинэчлэхтэй холбогдсон дээшлэт технологийн судалгаа хийх</p>	<p>2010-2011</p>	<p>МШХХТГ, Харилцаа холбооны зохицуулах хороо</p>	<p>2.5</p>	<p>Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт</p>
<p>2.8. Студийн тоног төхөөрөмжийг шинэчилж, тоон сүлжээгээр дамжуулах боломжийг бүрдүүлэх нэгдсэн хуваарь хийх</p>	<p>2011-2014</p>	<p>МШХХТГ, Харилцаа холбооны зохицуулах хороо</p>	<p>4,000.0</p>	<p>Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт</p>
<p>2.9. Тоон системийн тоног төхөөрөмжид тавигдах техникийн нөхцөл, шаврдлагыг тогтоож, баталгаажуулалтын тогтолцоог бий болгох</p>	<p>2011-2012</p>	<p>Харилцаа холбооны зохицуулах хороо</p>	<p>-</p>	<p>-</p>
<p>2.10. Тоон радио, телевизортой болон харгалзчийн тоног төхөөрөмж шинээр худалдан авах өрсийн судалгааг гаргах</p>	<p>2011-2015</p>	<p>МШХХТГ, Харилцаа холбооны зохицуулах хороо</p>	<p>5.0</p>	<p>Харилцаа холбооны зохицуулах хорооны санхүүжилт</p>
<p>2.11. Тоон телевизорын харгалзчийн хувиргач төхөөрөмж (set top box)-ийг худалдан авахад төрөөс дэмжлэг үзүүлэх</p>	<p>2015</p>	<p>МШХХТГ</p>	<p>10,000.0</p>	<p>Гадаадын зээл, тусламж</p>
<p>2.12. Хэрэглэчийн тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл, шаврдлагыг тогтоож, тэдгээрийн баталгаажуулалтын тогтолцоог бий болгох</p>	<p>2011-2012</p>	<p>Харилцаа холбооны зохицуулах хороо</p>	<p>-</p>	<p>-</p>

	<p>2.13. Монгол Улсад газрын сүлжээний радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологийг шилжүүлэх үе шатыг тодорхойлж, тоон радио, телевизийн системд шилжих нэгдсэн төлөвлөлт хийх</p>	<p>2010-2011</p>	<p>МШХХТТ, Харилцаа холбооны зохицуулах хороо</p>	<p>-</p>	<p>-</p>
<p>Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн тоон системд шилжүүлэх ажлыг нэгдсэн төлөвлөлтийн дагуу газар зүйн хувьд хэсэгчлэн үе шаттайгаар зохион байгуулах</p>	<p>3.1. Газрын сүлжээний тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн Туршилтын төслийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>2011</p>	<p>МШХХТТ, Харилцаа холбооны зохицуулах хороо</p>	<p>300.0</p>	<p>Бүтэцгүй Тусламж, хувийн хэвшлийн хөрөнгөөр</p>
<p>3</p>	<p>3.2. Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг анализ, тоон өргөн нэвтрүүлгийн сүлжээ нэгэн зэрэг ажиллах болон тоон технологийг бүрмөсөн шилжүүлэх үйл ажиллагааг газар зүйн хувьд хэсэгчлэн үе шаттайгаар нэгдсэн төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>2011-2015</p>	<p>МШХХТТ</p>	<p>-</p>	<p>-</p>
	<p>3.3. Монгол Улсад анализ, технологийг ашиглан радио, телевизийн өргөн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах үйл ажиллагааг 2014 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 00 цагт бүрэн зогсоож тоон технологийн системийг ашиглах эхлэх</p>	<p>2014</p>	<p>МШХХТТ, Харилцаа холбооны зохицуулах хороо</p>	<p>-</p>	<p>-</p>



Харилцаа холбооны зохицуулах хорооны сангуужилт	15.0	МШХХТТ, Харилцаа холбооны зохицуулах хороо	2011-2013	4.1. Радио, телевизийн тоон системд шилжсэн гадаад орны байгууллагын туршлага судлах, гадаад, дотоодын зөвлөх үйлчилгээ авах	Хөтөлбөрийг ажлын нэгдэл, иргэдэд байгууллага, сургалт зохион байгуулах
Харилцаа холбооны зохицуулах хорооны сангуужилт	40.0	МШХХТТ, Харилцаа холбооны зохицуулах хороо	2011-2015	4.2. Холбогдох заавар, зөвлөмж боловсруулж сурталчлах	
		МШХХТТ, Харилцаа холбооны зохицуулах хороо	2010-2012	4.3. Радио, телевизийн тоон системд шилжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа төслүүдийн үйлдвэр хэлбэр сайжруулж хөрөнгө даваардсан орүүлалтаас зайлсхийх, энэ чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлын талаархи мэдээллийг нэгтгэх	
Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	3.0	МШХХТТ, Харилцаа холбооны зохицуулах хороо	2011-2012	4.4. Тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн системийн чиглэлээр ажиллах	
Харилцаа холбооны зохицуулах хорооны сангуужилт	15.0	МШХХТТ, Харилцаа холбооны зохицуулах хороо	2011-2015	4.5. Иргэдийн дунд сургалт, сурталчилгаа зохион байгуулах	
Харилцаа холбооны зохицуулах хорооны сангуужилт	5.0	МШХХТТ, Харилцаа холбооны зохицуулах хороо	2011-2012	4.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнийг талаар уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах	

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ**2010 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар
хот**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг
шүүхийн практикт дагаж мөрдөх журмын тухай**

Улсын Их Хурлаас Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж, дагаж мөрдөх болсонтой холбогдуулан уг хуулийн зарим зүйл, хэсэг заалтыг нэг мөр ойлгож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ** нь:

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль /цаашид энэ хууль гэх/ Улсын Их Хурлын чуулганаар 2010 оны 10 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 3-т зааснаар "Төрийн мэдээлэл" сэтгүүлд хэвлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа буюу 2010 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон тул мөн өдрөөс өмнөх хугацаанд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэмэлт, өөрчлөлт ороогүй хуулийн дагуу, харин уг өдрөөс хойших ажиллагааг энэ хуулийн дагуу явуулна.

2. Хууль хүчин төгөлдөр болохоос өмнө захиргааны хэрэг үүсгэсэн, шийдвэрлэгдээгүй байгаа хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг 2010 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн энэ хуулийн дагуу үргэлжлүүлэн явуулна.

Нэмэлт, өөрчлөлт ороогүй хуулийн дагуу явуулсан бүх ажиллагаа хүчинтэй хэвээр байна.

3. Анхан шатны шүүхийн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт ороогүй хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т заасан гомдол гаргах хугацаа өнгөрөөгүй



бөгөөд давж заалдах, эсхүл хяналтын гомдол гаргаагүй байхад энэ хууль хүчин төгөлдөр болсон бол хууль хүчин төгөлдөр болсноос хойш гаргасан аль ч гомдлыг давж заалдах гомдол гэж үзэн хэргийг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэнэ.

4. Хууль хүчин төгөлдөр болохоос өмнө гаргасан давж заалдах гомдолтой хэргийг Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах журмаар хянан шийдвэрлэхдээ 2010 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн энэ хуулийг баримтална.

5. 2010 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс өмнө гаргасан давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын гомдол гаргах 30 хоногийн хугацаа дуусаагүй байхад хууль хүчин төгөлдөр болсон бол хууль хүчин төгөлдөр болсноос хойш гаргасан гомдолд энэ хуулийн 86 дугаар зүйлийн 86.5-д заасан хугацаа хамаарахгүй бөгөөд хэргийг хяналтын шатны шүүх хянан шийдвэрлэнэ.

6. Хууль хүчин төгөлдөр болохоос өмнө хяналтын шатны шүүх хүлээж авсан хэргийг энэ хуулийн дагуу хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ.

7. Хууль хүчин төгөлдөр болохоос өмнө анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан хяналтын гомдолтой хэргийг хяналтын шатны шүүх 2010 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс хойш хүлээж авсан бол хэргийг шүүгчийн захирамжаар давж заалдах шатны шүүхэд шилжүүлнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ц.ЗОРИГ

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

О.ЗАНДРАА

ШҮҮГЧ

Ч.ТУНГАЛАГ

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin_medeelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн дуудлаг 3.2/

Индекс: 14003